

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАЛААР ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНААС ГАРГАСАН ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан
хуралдаанаас дэмжээгүй санал:**

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх

- нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2027 онд 36,493.4 тэрбум төгрөг гэснийг 34,318.8 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 31.9 гэснийг 30.0 гэж, 2028 онд 38,644.0 тэрбум төгрөг гэснийг 36,355.9 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 30.4 гэснийг 28.6 гэж, 2029 онд 40,444.7 тэрбум төгрөг гэснийг 39,596.2 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 28.6 гэснийг 28.0 гэж;

- нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2027 онд 32,495.4 тэрбум төгрөг гэснийг 26,316.7 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 28.4 гэснийг 23.0 гэж, 2028 онд 34,827.4 тэрбум төгрөг гэснийг 27,963.6 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 27.4 гэснийг 22.0 гэж, 2029 онд 36,908.5 тэрбум төгрөг гэснийг 31,110.6 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 26.1 гэснийг 22.0 гэж;

- ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ 2027 онд 5.8 хувь гэснийг 6.3 хувь гэж, 2028 онд 6.0 хувь гэснийг 6.5 хувь гэж, 2029 онд 6.3 хувь гэснийг 6.0 хувь гэж;

- Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 2027 онд 7.0 гэснийг 6.5 гэж;

- Засгийн газрын өрийн нийт хэмжээ 2027 онд 57,114.9 тэрбум төгрөг гэснийг 51,403.4 тэрбум төгрөг гэж, 2028 онд 63,610.1 тэрбум төгрөг гэснийг 57,249.1 тэрбум төгрөг гэж тус тус өөрчлөх, эдгээр өөрчлөлттэй уялдуулан эдийн засгийн бусад үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийн тооцооллыг хийх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц